



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/367

Булган сум

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн цусны салбар
төвд дэмжлэг үзүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Донорын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн Цусны салбар төвийн 60 жилийн түүхэн ой тохиолдож байгаатай холбогдуулан бүтээгдсэн “Амьдрал бэлэглэсэн нэгэн жаран” номыг хэвлүүлэн, түгээхэд 4,800,000 (дөрвөн сая найман зуу мянга) төгрөгийн хөрөнгө, санхүүжилтийн дэмжлэг үзүүлсүгэй.

Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг “Эрүүл Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010506